



# **ХКОМ-ын хүрээнд МК-ийн хэрэгжүүлж буй Санаачилгын Ерөнхий Танилцуулга**

2026 оны 2-р сар

Мицубиши Корпораци




Байгаль Орчин, Эрчим Хүчний Групп

Нүүрстөрөгчийн Удирдлагын Хэлтэс.

# “Мицубиши Корпорац”-ийн Танилцуулга

• 600 Мицубиши нэртэй компаниуд байдаг

600

		
Joy brings us together 		
		
		
		
		
		
		
		
		
		
		

## 8 Бизнес Групп-ууд



- **1954 оны 7 сарын 1-нд** байгуулагдсан
- Ажилчдын тоо – **4,477**(дангаараа), **62,062**(нийт)
- Оффисын тоо – Японд **11** Оффис, Гадаадад **103** Оффистой
- Нийт охин болон салбар компаниуд - **1,196** Компаниуд

**Байгаль  
Орчин, Эрчим  
Хүчний Групп**

Тогтвортой эрчим хүчний нийлүүлэлтийг хангахын зэрэгцээ эрчим хүчний шилжилтийг идэвхтэй дэмжин, нүүрстөрөгчийн саармаг нийгэмд хувь нэмэр оруулахыг зорьдог.

**Дараагийн  
Үеийн Эрчим  
Хүчний Хэлтэс**

Хамтрагчид болон хэрэглэгчдийнхээ нүүрстөрөгч бууруулах хэрэгцээг хангах зорилгоор бага болон тэг нүүрстөрөгчийн шийдлүүдийг санал болгох.



Монгол дахь Төлөөлөгчийн Газар нь 2010 онд байгуулагдсан.

## ✓ УБ-ын Шинэ Нисэх Онгоцны Буудал

- 2019 онд Японы консорциум болон Монгол Улсын Засгийн газар хамтран нисэх буудлын үйл ажиллагаа эрхлэх компанийг байгуулсан(\*).
  - 2021 оны 7 сард онгоцны буудал үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
  - МК-аас хоёр Японы удирдах ажилтан (Гүйцэтгэх захирал/Санхүүгийн захирал) томилолтоор ажиллаж байгаа нь компанийн удирдлагын идэвхтэй оролцоог хангаж байна.
- (\* ) Япон 51%, Монгол 49%




## ✓ Ашигт Малтмалын Мэдээллийн Хөгжил


- Монгол Улс коксжих нүүрс болон зэсийн томоохон нөөцтэй. 2010 оны орчимоос эхлэн ашигт малтмалын том хэмжээний төсөл, хөгжүүлэлтүүд эрчимжсэн.
  - Манай Улаанбаатар дахь Төлөөлөгчийн газар нь ашигт малтмалын салбар дахь бизнесийн боломжуудыг өргөжүүлэх зорилгоор мэдээлэл-судалгааны үйл ажиллагаа явуулж байна.
- ## ✓ Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа
- Тэтгэлэгт Хөтөлбөр (2011–2021)
    - Монголын үндэсний их, дээд сургуулиудын 238 оюутанд тэтгэлэг олгосон.
  - Нийгмийн / Байгаль Орчны Дэмжлэг
    - 2014 оноос хойш нийт долоон төслийг дэмжин хэрэгжүүлсэн.
  - 2025 оны санаачилга
    - Дарханы “Нарны хүүхдүүд” асрамжийн газрын дэд бүтэц, сургалтын орчныг сайжруулах чиглэлд санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

# Ялгарлыг Бууруулах/Арилгах Зорилт: Нүүрстөрөгчийн Төслүүд

- Дэлхий даяар 100 гаруй төслийг нягтлан судалж, ой болон хөдөө аж ахуйтай холбоотой шинэ төслүүдийг боловсруулах, хөрөнгө оруулах ажлыг явуулж байна.



- Бид технологид суурилсан нүүрстөрөгчийн кредитийг дэлхий даяар хөгжүүлэх ажилд ахиц гаргаж, NextGen арилжааны платформоор дамжуулан зах зээлийн уялдаа холбоог бэхжүүлж байна.



\*DACCS: Агаараас шууд барих ба нүүрстөрөгч хадгалалт  
 \*\*BECCS: Нүүрстөрөгч барилт ба хадгалалттай био-эрчим хүч  
 \*\*\*ERW: Чулуулгийн эрчимжүүлсэн өгөршил

# **ХКОМ-ын Хүрээнд Хэрэгжүүлж буй Санаачилга**

## Будааны Метан (AWD)



AWD будааны метаны төсөл нь ус хэмнэх усалгааны аргачлалыг нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, тогтвортой байдлыг сайжруулан, орон нутгийн фермерүүдийн уур амьсгалд ээлтэй хөдөө аж ахуйн хөгжлийг дэмждэг.

Байршил: Зүүн Өмнөд Ази  
ХХЯ-ыг бууруулах зорилт: > нэг төслөөс жилд 100 мянган т CO<sub>2</sub>  
Харилцан үр ашиг: Усалгааны зардал буурна, тогтвортой байдал нэмэгдэнэ

## Биохий



Шахсан биохийн төсөл нь органик хаягдлыг цэвэр түлш болгон хувиргаж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулан, нүүрстөрөгчийн кредит бий болгодог бөгөөд орон нутаг, аж үйлдвэрүүдэд тогтвортой эрчим хүчний хөгжлийг дэмждэг.

Байршил: Энэтхэг, Индонез  
ХХЯ-ыг бууруулах зорилт: Төслөөс жилд <30 мянган т CO<sub>2</sub>  
Харилцан үр ашиг: Агаарын бохирдлыг бууруулна, Хаягдлын менежментийг сайжруулна

## Хөрсний Нүүрстөрөгч



Тогтвортой бэлчээрлэлийн аргыг нэвтрүүлэх замаар бэлчээрийн экосистемийг сэргээж, улмаар хөрсөнд нүүрстөрөгч шингээх ба тогтоох процессыг эрчимжүүлдэг.

Байршил: Монгол  
Арилгах зорилт: >Жил бүр нэг төслөөс 1+ сая т CO<sub>2</sub>  
Харилцан үр ашиг: Цөлжилтөөс сэргийлнэ, мал аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлнэ

## Сэргээгдэх эрчим хүч нэвтрүүлэлт ба эрчим хүчний шилжилт



Нүүрсний станцыг 10 жилээр эрт хаан, сэргээгдэх эрчим хүчээр орлуулах нь Зүүн Өмнөд Азийн декарбонизацийг дэмжих онцлох санаачилга болж байна.

Байршил: Филиппин  
ХХЯ-ыг бууруулах зорилт: Төслөөс жилд <2 сая т  
Харилцан үр ашиг: Агаарын чанарыг сайжруулна, эрүүл мэндийн эрсдэл бууруулна

- Монгол Улсад ойролцоогоор 110 сая га хэмжээтэй нийтийн бэлчээрийн газар бий. Эдгээр нь хэт бэлчээрлэлтээс шалтгаалсан цөлжилтийн эрсдэлд өртөж байна.
- Бид хэт бэлчээрлэлтийг бууруулж, бэлчээрийн экосистемийг сэргээн нөхөн төлжүүлэх зорилго бүхий тогтвортой бэлчээрлэлийн аргыг нэвтрүүлэхийг зорьж байна.

✓ **Төслийн үе шат:** Урьдчилсан ТЭЗҮ

✓ **Эхний кредит олгох хуваарь:** 2028 он хавьцаа (зорилт)

✓ **Нүүрстөрөгчийн кредит:** Жилд ойролцоогоор 1 сая т CO<sub>2</sub> (зорилт)

✓ **Кредитийн хугацаа:** 15 жил (урьдчилсан)

✓ **Хүлэмжийн хийн ялгаралд үзүүлэх нөлөө:**

Монгол Улсад бэлчээрийн цөлжилт, хөрсний органик нүүрстөрөгчийн алдагдал, мөн экосистемд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь ноцтой асуудал болоод байна.

Бэлчээрийг сэргээхийн тулд тогтвортой бэлчээрлэлийн арга нэвтрүүлэх нь хөрсний органик нүүрстөрөгчийг нэмэгдүүлж, улмаар нүүрстөрөгч шингээлтийг сайжруулахад тусалдаг.

✓ **Эрсдэлийг бууруулах (Био төрөл зүйл ба Эдийн засаг)**


Бэлчээрийг сэргээх нь биологийн олон янз байдлын алдагдлын эрсдэлийг бууруулах бөгөөд бэлчээрийн цөлжилтэд өртсөн малчдын эдийн засгийн эрсдэлийг багасгахад тусалдаг.

✓ Энэ төсөл нь хөрсний органик нүүрстөрөгчийг нэмэгдүүлэхийн тулд тогтвортой бэлчээрлэлийн аргууд, ялангуяа эргэлтийн бэлчээрлэлтийг нэвтрүүлэхийг зорьж байна.

✓ Эргэлтийн бэлчээрлэлт нь мал сүргийг өөр өөр хэсэгт ээлжлэн бэлчээж, бусад хэсгийг амрааж, нөхөн сэргээх боломж олгодог аргачлал юм.

✓ Эргэлтийн бэлчээрлэлт нь ургамлын өсөлтийг сайжруулж, нүүрстөрөгч шингээлт нэмэгдэж, хөрсний бүтэц сайжирч, усны нөөцийг барих чадвар болон био төрөл зүйл, экосистемийн олон янз байдал нэмэгдэх зэрэг ач холбогдолтойгоос гадна эрүүл экосистем, уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй ландшафт бий болгоход тусалдаг.

**Төслийн хэрэгжилтийн зураг**



Одоогийн (хэт бэлчээрлэлт)

Төсөл (Тогтвортой бэлчээрлэлт)

Энэхүү баримт бичгийг Мицубиши Корпораци бие даан боловсруулсан болно.

Энэ баримт бичигт багтсан мэдээллийн зарим хэсэг нь зохиогчийн зөвшөөрөл аваагүй байж болохыг анхаарна уу.

Энэхүү баримт бичигтэй холбоотой аливаа шийдвэр гаргахаас өмнө өөрийн байгууллагын хуульч, нягтлан бодогч, татварын зөвлөх зэрэг мэргэжилтнүүдтэй зөвлөлдөхийг хүсье.

Энэ баримт бичгийг сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, хувийн судалгааны байгууллагуудын хэвлэлүүд, интернет вэбсайтууд, аюулгүй ажиллагааны тайлан, хэвлэлийн мэдээ зэрэг эх сурвалжид тулгуурлан боловсруулсан бөгөөд эдгээр мэдээллийг Мицубиши Корпораци нь бие даасан шалгалтгүйгээр шууд ашигласан тул үнэн зөв, бүрэн бүтэн байдалд хариуцлага хүлээхгүй болно.